



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠒ оны ᠐᠔ сарын ᠒᠐ өдөр

Дугаар ᠒/80


Улаанбаатар хот

Төсөвт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын Цаг уурын байгууллагууд болон Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаадад шаардлагатай тоног төхөөрөмж, эко ариун цэврийн байгууламжийг шийдвэрлэх зорилгоор хавсралтын дагуу төсөвт зохицуулалт хийсүгэй.

2.Төсвийн зохицуулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх ажлыг зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга (С.Цогтгэрэл)-д даалгасугай.



Б.Бат-Эрдэнэ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Б.НМ-Осогов
Замууны хэргийн
хэргийн
хэргийн
хэргийн



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2024 оны дугаар сарын өдрийн
дугаар тушаалын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
БАГЦЫН ТӨСӨВТ ХИЙХ ЗОХИЦУУЛАЛТ

	Байгууллага/Хөтөлбөр	НИЙТ	Эдийн засгийн ангилал			
			Нэмэгдэл цалин	Багаж, техник, хэрэгсэл	Урсгал засвар	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээ
	НИЙТ		(3,483,100)	2,765,600	15,000	702,500
1	БОАЖЯ /ХБОБУ хөтөлбөр/	(3,483,100)	(3,483,100)			
	Тусгай хамгаалалтын захиргаад	36,000		36,000		
1	Зэд хантай бүтээлийн нурууны ДЦГ	12,000		12,000		
2	Хөвсгөлийн УТХГ	12,000		12,000		
3	Улаан тайгын УТХГ	12,000		12,000		
	Цаг уурын байгууллагууд	3,447,100		2,729,600	15,000	702,500
1	Архангай аймгийн УЦУОШТ	129,200		119,200		10,000
2	Баян-өлгий аймгийн УЦУОШТ	105,700		90,700		15,000
3	Баянхонгор аймгийн УЦУОШТ	145,900		125,900		20,000
4	Булган аймгийн УЦУОШТ	175,800		148,300	15,000	12,500
5	Говь-Алтай аймгийн УЦУОШТөв	140,900		125,900		15,000
6	Дорноговь аймгийн УЦУОШТ	128,600		116,100		12,500
7	Дорнод аймгийн УЦУОШТ	106,000		96,000		10,000
8	Дундговь аймгийн УЦУОШТ	114,500		99,500		15,000
9	Завхан аймгийн УЦУОШТ	155,600		135,600		20,000
10	Өвөрхангай аймгийн УЦУОШТ	135,600		120,600		15,000
11	Өмнөговь аймгийн УЦУОШТ	109,500		99,500		10,000
12	Сүхбаатар аймгийн УЦУОШТ	102,600		95,100		7,500
13	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	106,600		91,600		15,000
14	Төв аймгийн УЦУОШТ	169,200		141,700		27,500
15	Увс аймгийн УЦУОШТ	139,700		119,700		20,000
16	Ховд аймгийн УЦУОШТ	128,300		108,300		20,000
17	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	187,500		160,000		27,500
18	Хэнтий аймгийн УЦУОШТ	133,600		113,600		20,000
19	Дархан аймгийн УЦУОШТ	52,000		52,000		
20	Орхон аймгийн УЦУОШТ	46,700		46,700		
21	Говьсүмбэр аймгийн УЦУОШТ	38,600		36,100		2,500
22	Улаанбаатар УЦУОШТ	59,400		51,900		7,500
23	Цаг уур, орчны шинжилгээний газар	400,000				400,000



24	Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн	329,000		329,000		
25	Байгаль орчны шинжилгээний төв лабортори	50,200		50,200		
26	Нисэх УЦУОШТ	56,400		56,400		

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Ерөнхий гэрээний дагуу худалдан авах гэрээ

2024-02-26 Гэрээний дугаар : ЗААУЦУОШТ/004/001 Завхан аймаг

Энэхүү гэрээг нэг талаас "Ай Ти Зон" ХХК, /цаашид "Гүйцэтгэгч" гэх/, нөгөө талаас Завхан аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв, /цаашид "Захиалагч" гэх/ дараах зүйлсийг харилцан тохиролцож 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр гэрээг байгуулав.

Нэгдүгээр зүйл. Нийтлэг үндэслэл

- 1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Иргэний хууль, Ерөнхий гэрээний журам болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу Ерөнхий гэрээгээр бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго оршино.
- 1.2 Захиалагч нь Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтын арга болох **Үнийн санал авах арга**-ндагуу Цахим дэлгүүрт ирүүлсэн худалдан авалтын хуудаст заасан бараа, үйлчилгээг гүйцэтгэх гүйцэтгэгчийн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хоёрдугаар зүйл. Гэрээний агуулга

- 2.1 Гэрээний зүйл: Цахим дэлгүүрийн бараа нийлүүлэх гэрээ
- 2.2 Үнийн хуваарь:

№	Барааны код	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Санал болгосон үнэ	Нийт дүн
1.	PRINTER_01	Олон үйлдэлт принтер	Ширхэг	1	750,000	750,000
2.	PC_TOWER_I5	Суурин компьютер /i5/	Ширхэг	14	2,650,000	37,100,000
3.	Web Camera	Веб камер C280	Ширхэг	8	189,900	1,519,200
4.	Tablet /256/	Таблет /256/	Ширхэг	1	3,699,000	3,699,000
5.	Wireless Mouse	Утасгүй хулгана	Ширхэг	2	41,000	81,800

Гэрээний нийт дүн: 43,150,000 /Усгээр/: **дөчин гурван сая нэг зуун тавин мянга төгрөг**

2.3 Бараа хүргэх/хүлээн авах төрөл: **Тийм**

Бараа хүргэх/ хүлээн авах хаяг :

2.4 Нийлүүлэлтийн хийх хугацаа: Гэрээ байгуулагдсанаас хойш 18 хоногийн дотор бараа нийлүүлж дуусгасан байна.

/иж бүрдэлд барааны биет байдлын шинжийг тодорхойлж буй бараа түүнийг дагалдах үйлчилгээ, тоног төхөөрөмж эсхүл үйлчилгээ түүнийг дагалдах бараа, материал, тоног төхөөрөмж, сургалт, суурьлуулалт, шалгалт, туршилт зэрэг холбогдох мэдээллийг оруулна./

2.5 Гүйцэтгэгч бараа, үйлчилгээнд холбогдох аливаа баримт бичгийг захиалагчид бараа, үйлчилгээг Ачуулах - р шилжүүлнэ.

2.6 Гүйцэтгэгч бараа, үйлчилгээнд холбогдох аливаа баримт бичгийг захиалагчид бараа, үйлчилгээг [ачуулснаар эсхүл хүлээлгэн өгөх] /аль тохирохыг сонгох/ -ээр шилжүүлнэ.

Гуравдугаар зүйл. Чанарын баталгаа, баталгаат засвар

- 31 Гүйцэтгэгчийн нийлүүлэх бараа, үзүүлэх үйлчилгээ нь Цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, үйлчилгээний тодорхойлолттой ижил байх бөгөөд чанарын шаардлагыг бүрэн хангасан байна.
- 32 Чанарын шаардлагыг техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, барааны чанарыг тодорхойлох улсын стандарт, үйлдвэрлэгчийн гэрчилгээ, загвар зэрэг холбогдох баримт бичигт үндэслэнэ.
- 33 Баталгаат хугацаа нь барааг нийлүүлж, үйлчилгээг үзүүлснээс хойш 36 сарын хугацаатай байна.
- 34 Захиалагч баталгаат хугацаанд бараа, үйлчилгээний аливаа дутагдал доголдол, гэмтлийн талаар гүйцэтгэгчид нэн даруй мэдэгдэх бөгөөд гүйцэтгэгч мэдэгдэлд заасан хугацааны дотор гэмтэл согогтой бараа, дутагдалтай үйлчилгээг үнэ төлбөргүй, шуурхай засварлах буюу солино.
- 35 Гэрээний 3.4 дэхь хэсэгт заасан бараа, үйлчилгээний гэмтэл, согог, дутагдлыг арилгаснаас хойш 12 сарын дотор уг бараа, үйлчилгээнд энэ төрлийн гэмтэл согог дутагдал дахин гарсан бол уг гэмтэл согог, дутагдлыг гүйцэтгэгч үнэ төлбөргүй шуурхай арилгана.





Дөрөвдүгээр зүйл. Үнэ төлбөр, төлбөрийн нөхцөл, нэхэмжлэл

- 4.1 Захиалагч нь бараа, үйлчилгээг хүлээн авч, Ерөнхий гэрээний хоёрдугаар шатны шалгаруулалтад ирүүлсэн нэгж үнэд үндэслэсэн гүйцэтгэгчийн нэхэмжлэлийн дагуу төлбөрийг төлнө.
- 4.2 Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ бүрэн биелүүлсний дараагаар төлбөр хийхийг хүссэн хүсэлтийг төлбөрийн нэхэмжлэх болон 2.6 дахь хэсэгт заасан баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ.
- 4.3 Гүйцэтгэгч 4.2 дахь хэсэгт заасан баримт бичгийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор төлбөрийг шуурхай гүйцэтгэнэ.
- 4.4 Төлбөрийн төрөл: Банкны шилжүүлэг
- 4.5 Захиалагч төлбөр гүйцэтгэсэн хоногт багтаан гүйцэтгэгчид төлбөр төлсөн талаар энэ гэрээнд заасан харилцах хаягаар мэдэгдэнэ.

Тавдугаар зүйл. Сав баглаа боодол

- 5.1 Гүйцэтгэгч барааг аюулгүй баглаа боодолд хийж, захиалагчид барааг хүлээн авах хүртэл гэмтэл эвдрэл, устхаас сэргийлж баталгаажуулна.
- 5.2 Барааны нэгж үнэ нь тээвэрлэлтийн зардал багтсан үнэ бол баглаа боодлын үнэ нь уг үнэд багтсан байна.
- 5.3 Баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ захиалагчийн дараах зааварчилгааг чанд мөрдөнө:
Завхан аймгийн Улиастай суманд хүргэгдэх учраас эвдрэл гэмтэл гарахгүйгээр боож баглах.

Зургаадугаар зүйл. Барааг хүлээн авах

- 6.1 Гүйцэтгэгч нь захиалагчид Монгол, Завхан, Улиастай сум, 5-р баг -т барааг хүлээлгэн өгнө.
- 6.2 Талууд хүлээн авах цэг дээр барааны тоо хэмжээ, чанарыг хуульд заасан арга ажиллагааны дагуу шалгана.
- 6.3 Захиалагч гүйцэтгэгчид бараа/ үйлчилгээг нийлүүлсний дараа 2024-03-30 хугацаан дотор телеграм, факс/-аар мэдэгдэнэ.

Долоодугаар зүйл. Гэрээний хүчин төгөлдөр байдал

- 7.1 Энэхүү гэрээ талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Гэрээ нь 2024-03-30 өдөр дуусгавар болно.

Наймдугаар зүйл. Тусгай нөхцөл

.....
.....

Есдүгээр зүйл. Бусад зүйл

- 9.1 Энэхүү гэрээ хоёр хувь үйлдэгдэх бөгөөд талуудад нэг нэг хувь хадгалагдана.
- 9.2 Талууд энэхүү гэрээнд гарын үсэг зурснаар гэрээний өмнөх хэлэлцээр, харилцаа холбоо, зөвлөмж, санал хүчингүй болно.
- 9.3 Гүйцэтгэгчтэй байгуулсан Ерөнхий гэрээ, Цахим дэлгүүрт бүртгэгдсэн барааны техникийн тодорхойлолт, үйлчилгээний ажлын даалгавар, худалдан авалтын хуудас нь тус гэрээний салшгүй хэсэг болно.
- 9.4 Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг гэрээг зөрчих, цуцлахтай холбоотой аливаа маргаантай асуудлыг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв зөвшилцөлд үл хүрвэл Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

Аравдугаар зүйл. Гэрээтэй холбоотой асуудлаар харилцах талуудын мэдээлэл





Төлөөлөгчийн нэр:	Гүйцэтгэгч	Захиалагч
Албан тушаал:	Ч.Гончигсумлаа	Б.Ням-Осор
Холбоо барих мэдээлэл:	Төслийн мэргэжилтэн	Ахлах нягтлан
	89110617	Nyamosor_bidrya@yahoo.com, 94009292
Хаяг:	Ай Ти Зон ХХК, 22 давхар, Хаан банк цамхаг, Чингисийн өргөн чөлөө-6, Стадион Оргил-1, Хан-Уул дүүрэг, Улаанбаатар 17010, Монгол улс	Монгол, Завхан, Улиастай сум, 5-р баг
Харилцах банкны нэр:	ХХБанк	
Харилцах дансны дугаар:	499026123 (₮)	

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгчийн төлөөлж:

"Ай Ти Зон ХХК"-ийн Гүйцэтгэх захирал
У.Эрдэнэбаяр

[Гарын үсэг]

ТАМГА

"Ай Ти Зон ХХК"-ийн Төслийн хэлтсийн дарга
Б.Отгонбилэг

[Гарын үсэг]

"Ай Ти Зон ХХК"-ийн Төслийн мэргэжилтэн
Ч.Гончигсумлаа
[Гарын үсэг]

Захиалагчийг төлөөлж:

Завхан аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний
төвийн дарга Э.Мөнгөнцэцэг

[Гарын үсэг]

ТАМГА

Ахлах нягтлан Б.Ням-Осор

[Гарын үсэг]





Ерөнхий гэрээний дагуу худалдах, худалдан авах гэрээний
нэмэлт гэрээ

Дугаар № ЗААУЦУОШТ/004/001

2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр

Завхан аймаг

1. Нэг талаас Завхан аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас Ай Ти Зон ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

2. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

3. Захиалагч нь ЗААУЦУОШТ/004/001 дугаартай Ерөнхий гэрээний дагуу худалдах, худалдан авах нэмэлт гэрээг 3,000,000 /гурван сая/ төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

4. Нийлүүлэгч нь Олон үйлдэлт принтер нэр төрлийн барааг 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

6. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

Гэрээ байгуулсан:

Гүйцэтгэгчийн төлөөлж:

Захиалагчийг төлөөлж:

"Ай Ти Зон ХХК"-ийн Гүйцэтгэх захирал

У.Эрдэнэбямба

[Гарын үсэг]

"Ай Ти Зон ХХК"-ийн Төслийн хэлтсийн
дарга Б.Отгонбилэг

[Гарын үсэг]

"Ай Ти Зон ХХК"-ийн Төслийн
мэргэжилтэн Ч.Гоннигсумпаа

[Гарын үсэг]

Завхан аймгийн Ус цаг уур орчны
шинжилгээний төвийн дарга
Э.Мөнгөнцэцэг

[Гарын үсэг]

Ахлах нягтлан Б.Ням-Осор

[Гарын үсэг]



“.....” нэмэлт гэрээний хавсралт 1

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

№	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Нэгж үнийн дүн	Нийт дүн	Нийлүүлэх хугацаа
1	Олон үйлдэлт принтер	4	750,000 ₮	3,000,000 ₮	Гэрээ байгуулснаас хойш 18 хоногийн дотор